# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (543)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Түр журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2008 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2008 оны тавдугаар сарын 14 | №18 (543)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 244. | Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай | | 438 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 245. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 107 | 438 |
| 246. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 108 | 439 |
| 247. | Пүрэвжавын Хаянхярваад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 109 | 445 |
| 248. | Чүлтэмын Лхагважавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 110 | 445 |
| 249. | Дашийн Содномгомбод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 111 | 445 |
| 250. | Цэдэвийн Цэрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 112 | 445 |
| 251. | Баарангийн Пүрэвдашид Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 113 | 446 |
| 252. | Баатарын Рагчаад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 114 | 446 |
| 253. | Махзандарын Нямжилд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 115 | 446 |
| 254. | Жаграагийн Доржсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 116 | 446 |
| 255. | Равдангийн Дүгэрсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 117 | 447 |
| 256. | Лувсанчойдорын Алтанцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 118 | 447 |
| 257. | Далхжавын Болормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 119 | 447 |
| 258. | Зарим хүмүүсийг шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 120 | 447 |
| 259. | Зарим хүмүүсийг аймаг, нийслэл, сум дундын шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 121 | 448 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 260. | Түр журам батлах тухай | Дугаар 72 | 448 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 261. | Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 02 | 453 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 267, 272 дугаар зүйлийг тус тус нэмсүгэй:

**1/ 267 дугаар зүйл:**

**"267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих**

267.1.Албан тушаалтан бус этгээд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр барьж үйл ажиллагаа явуулсан нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжгүй бөгөөд энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний ашиг олсон, эсхүл бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ."

**2/ 272 дугаар зүйл:**

**"272 дугаар зүйл. Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах**

272.1.Албан тушаалтан хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавaас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

272.2.Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

**2 дугаар зүйл.** 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн "267 дугаар зүйл, 272 дугаар зүйл," гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2008 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсандагвын Энхтайваныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жаргалсайханы Энхсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр** **Дугаар 108** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, онцгой байдал, стандартчилал, хэмжилзүй, газрын харилцаа, геодези, шүүх, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Цоодолын Баатар - Өвөрхангай аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
2. Уламбаярын Барсболд - МАХН-ын нарийн бичгийн дарга
3. Цэвээндоржийн Баярмаа - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Булигаар" ХК-ийн мастер, технологич
4. Дамирансүрэнгийн Гансүх - Төв аймгийн шүүхийн шүүгч
5. Галзангийн Даваасамбуу - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт
6. Гэндэнгийн Дагвадорж - Ховд аймгийн Дарви сумын малчин
7. Цэндийн Дамдин - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт
8. Дугажийн Дамдиндорж - Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч
9. Мөнхнасангийн Дамирансүрэн - Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга
10. Намжилын Данаажав - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт
11. Долцонгийн Дондог - Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
12. Оросоогийн Зандраа - Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн
13. Раднаажавын Лхамсүрэн - Монголын урчуудын эвлэлийн хорооны чөлөөт уран бүтээлч
14. Чулууны Нямсүрэн - Хөвсгөл аймгийн Тариалан сумын дунд сургуулийн математикийн багш
15. Цэрэндашийн Оюунбаатар - Монголын "Тэмээн поло" холбооны тэргүүн
16. Батын Равдансамбуу - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөх, ахмад ажилтан
17. Осорын Сампил - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөх, ахмад ажилтан
18. Даржаагийн Совдоо - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын дарга
19. Хайнзангийн Содномцэрэн - Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш
20. Бэгзийн Цогзолмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 76 дугаар сургуулийн захирал
21. Задийн Цэнгэлсайхан - Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Балжиннямын Адьяа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш
2. Тайсаагийн Алтанцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн түүхийн багш
3. Чойжамцын Баасанбямба - Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
4. Галданжавын Баасанжав - Төв аймгийн Зуунмод сумын 5 дугаар сургуулийн бага ангийн багш
5. Намсрайн Баатарсүрэн - Ховд аймгийн 2 дугаар сургуулийн технологийн багш
6. Нямын Бадамрагчаа - СЭЗДС-ийн тэнхимийн эрхлэгч
7. Одхүүгийн Базар - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
8. Дамдинжавын Батаа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 92 дугаар сургуулийн сургалтын менежер
9. Зинаагийн Батбаяр - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт
10. Базаргүрийн Батжаргал - "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Дорнод аймаг дахь салбарын захирал

11. Сандагжавын Батжаргал - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн ахмад ажилтан

12. Дашдоржийн Батсүх - Сэлэнгэ аймгийн 6 дугаар сургуулийн захирал

13. Дэмбэрэлийн Батсүх - "Хань" сонины ерөнхий эрхлэгч

14. Цэрэннадмидын Батсүрэн - Дорнод аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

15. Пүрэвийн Баяраа - МҮОНРТ-ийн найруулагч

16. Магсарын Буянбат - Нийслэлийн Баянзүрх дүүргийн МАХН-ын хорооны Ахмадын холбооны дарга

17. Чимэдцэдэнгийн Ган-Өлзий - ШУА-ийн Философи, социологийн эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

18. Доржийн Гансүрэн - Хэнтий аймгийн Өлзийт тосгоны холбооны салбарын эрхлэгч

19. Өлзийбуянгийн Даваасамбуу - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 72 дугаар сургуулийн математикийн багш

20. Жамбажамцын Дамчигбал - Булган аймгийн Стандартчилал, хэмжилзүйн төвийн нягтлан бодогч

21. Ономын Дашдорж - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийн математикийн багш

22. Дагдандоржийн Дорж-Очир - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын "Түмэнцогт" ОНӨҮГ-ын захирал

23. Рэнцэнжамцын Дэжиддагва - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн зураг хөдөлмөрийн багш

24. Сангийн Дэжид-Осор - Нийслэлийн санхүүгийн "НИММ–Аудит" ХХК-ийн аудитор

25. Мэндээгийн Жаргалсүрэн - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Эрдмийн ундраа" лицей сургуулийн математикийн багш

26. Доржийн Ичинхорлоо - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 7 дугаар сургуулийн технологийн багш

27. Цэвээндоогийн Ишгэн - Дорнод аймгийн ҮЭ-ийн холбооны зохион байгуулагч

28. Чойжавын Лувсанжав - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны өндөр настан, "Д.Сүхбаатар" судлалын төвийн захирал

29. Ринчингийн Лхүндэв - Дорнод аймгийн Газрын албаны мэргэжилтэн

30. Сүрэнхорын Махбариад - Хөвсгөл аймгийн Их-Уул сумын сум дундын хүн эмнэлгийн хүүхдийн их эмч

31. Цэндийн Монгол - Монгол цэргийн музейн интерьерийн зураач

32. Жакейгийн Монголхаан - Нийслэлийн Налайх дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, ахмад уурхайчин

33. Мажигсүрэнгийн Мөнгөнбаяр - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Итгэмжлэлийн газрын дарга

34. Батдоржийн Мөнх-Амгалан - Нийслэлийн Баянгол дүүргийн 88 дугаар цэцэрлэгийн багш

35. Батбилэгтийн Мэнджаргал - ХХААЯ-ны ахлах мэргэжилтэн

36. Пандийн Мягмаржав - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны өндөр настан, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан

37. Галдандоржийн Налжирмаа - Булган аймгийн Хангал сумын дунд сургуулийн бага ангийн багш

38. Жунхүүгийн Наранхүү - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн ахлах мэргэжилтэн

39. Санжаадоржийн Наранцэцэг - П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн дотрын их эмч

40. Мянганы Наянбуу - Завхан аймгийн Стандартчилал, хэмжилзүйн төвийн улсын шалгагч

41. Цэрэнгийн Нина - "Энх-Орчлон" коллежийн сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч

42. Зундуйн Норжидмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 16 дугаар хорооны Ахмадын зөвлөлийн дарга

43. Долгорын Нэргүй - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн улсын шалгагч

44. Нацагдоржийн Нямсүрэн - Улсын циркийн жүжигчин

45. Равжирын Оюун - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Эрдэнэзул" ХХК-ийн ерөнхий захирал

46. Лхагвын Оюунбат - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн түүхийн багш

47. Гончигийн Оюунбилэг - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын малчин

48. Халзангийн Оюунбилэг - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дэд захирал

49. Ядамжавын Оюундэлгэр - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 19 дүгээр цэцэрлэгийн багш

50. Хорлоогийн Оюунсүрэн - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн орос хэлний багш

51. Цэрэндоржийн Өлзийноров - Төмөр замын коллежийн орлогч захирал

52. Цэрэнгомбын Пүрэв - ШУА-ийн Философи, социологийн эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

53. Дамбын Ринчинмядаг - Дархан-Уул аймгийн 4 дүгээр сургуулийн захирал

54. Гомбын Санжмятав - Нийслэлийн эрүүл мэндийн хувийн "Микроб" оношлогоо эмчилгээний лабораторийн эрхлэгч

55. Даш-Онолтын Сосорбурам - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш

56. Даваахүүгийн Сүхтогоо - СУИС-ийн сургалтын бодлого зохицуулалт, хяналтын албаны дарга

57. Будсүрэнгийн Сэлэнгэ - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 49 дүгээр сургуулийн зураг хөдөлмөрийн багш

58. Чимэддамбын Таамаа - МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн хятад хэлний багш

59. Түвшинбаярын Хадборгил - Дорнод аймгийн "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн хэлтсийн дарга

60. Цэстийн Хатанбаатар - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн математикийн багш

61. Сүхбаатарын Хийморсан - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Сайхан халиун" ХХК-ийн ерөнхий захирал

62. Лодонгийн Хишигт - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар сургуулийн монгол хэлний багш

63. Намжилсүрэнгийн Хүрэлбаатар - Дорнод аймгийн Засаг даргын орлогч

64. Гүржавын Хүрэлчулуун - Булган аймгийн худалдаа үйлчилгээний "Шинэ тэнгис" ХХК-ний захирал

65. Гунгаагийн Цагаандарь - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн сувилагч

66. Егнэнгийн Цэвээн - Увс аймгийн "Чандмань-Эрдэм" ахлах сургуулийн дунд ангийн сургалтын менежер

67. Доржийн Цэрэн - Дорнод аймгийн Баян-Уул сумын 6 дугаар багийн Засаг дарга

68. Бямбажавын Цэрэннадмид - МҮОНРТ-ийн ээлжийн ахлах инженер

69. Дамдинсүрэнгийн Цэрэнханд - Хотын түргэн тусламжийн төвийн диспетчер

70. Дамчаагийн Цэрэнханд - Дорнод аймгийн Баяндун сумын нийгмийн даатгалын байцаагч

71. Баянпунцагийн Цэцэгмаа - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "ТБД-Андууд" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

72. Очирын Чинбат - "МОНЦАМЭ" "Новости Монголия" сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга

73. Хайдавгэлэгийн Чулуунбаатар - Дорнод аймгийн "Дорнод туг" ХХК-ийн захирал

74. Тоомойн Чулуунхүү - Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын газрын даамал

75. Цэдэвсүрэнгийн Шатар - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 жилийн 2 дугаар сургуулийн сургалтын менежер

76. Балсангийн Энхбат - "TV-9" телевизийн маркетингийн албаны дарга

77. Бумбилайн Энхээ - Увс аймгийн Тариалан сумын "Довт" хоршооны захирал

78. Цэдэндоржийн Эрдэнэбаатар - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн зургийн багш

79. Дашзэвэгийн Эрдэнэчулуун - Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга

80. Нингэрийн Эрдэнээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны Ахмадын зөвлөлийн дарга

81. Лхамсүрэнгийн Янжин - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 114 дүгээр сургуулийн математикийн багш

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Дашцэрэнгийн Адъяа - Нийслэлийн газрын мэргэжлийн байгууллага "Топсүрвэй" ХХК-ийн жолооч

2. Дуламын Адъяабазар - ХААИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах багш

3. Содномын Алимаа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 92 дугаар сургуулийн биологийн багш

4. Дашжамцын Алтантуяа - Хэнтий аймгийн Биндэр сумын хүн эмнэлгийн их эмч

5. Доржийн Алтанцэцэг - Хөвсгөл аймгийн Сум дундын шүүхийн шүүгч

6. Оргодолын Алтанцэцэг - Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн сургалтын менежер

7. Цэдэвсүрэнгийн Алтанцэцэг - Нийслэлийн Газрын албаны ерөнхий санхүүч

8. Сампилын Алтанцэцэг - "МОНЦАМЭ", "Хүмүүн бичиг" сонины сурвалжлагч, менежер

9. Цэвэгмэдийн Бадамжав - Дархан-Уул аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн багш

10. Пүрэвжавын Байгалмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн химийн багш

11. Цэвэгжавын Батсуурь - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн бага ангийн багш

12. Чүлтэмийн Батхүү - Нийслэлийн Баянгол дүүргийн сургалт үйлдвэрлэлийн "Сэтгэмж" цогцолбор сургуулийн сургалтын ерөнхий менежер

13. Даваасамбуугийн Баянхүү - Нийслэлийн Баянгол дүүргийн "Монгени" цогцолбор сургуулийн монгол хэлний багш

14. Сүнгээгийн Баярмаа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 52 дугаар сургуулийн бага ангийн багш

15. Самбуугийн Баярчулуун - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн улсын шалгагч

16. Алтангэрэлийн Болд - Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга

17. Загдын Бурмаа - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн бага ангийн багш

18. Даваагийн Буян-Орших - Дундговь аймгийн Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн багш

19. Энхээгийн Буянхүү - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны Засаг дарга

20. Шаравын Бүдваа - Төв аймгийн Борнуур сумын дунд сургуулийн хөдөлмөрийн багш

21. Нямцэрэнгийн Бямбажав - Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын хүн эмнэлгийн их эмч

22. Энэбишийн Бямбацэцэг - "Монголчуудын амьдрал" сонины ерөнхий эрхлэгч

23. Сосорбурамын Ганбат - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тасгийн их эмч

24. Гуудайн Гандмаа - Улсын дээд шүүхийн Мэдээлэл, лавлагааны албаны зааварлагч

25. Цэдэнбалжирын Гандолгор - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн лабораторийн эрхлэгч

26. Чүлтэмийн Ганцоож - Хэнтий аймгийн Норовлин сумын цэцэрлэгийн эрхлэгч

27. Очирчүлтэмийн Гүнжидмаа - Мэргэжлийн өвчин судлал, эмнэлэг хөдөлмөр магадлалын төвийн мэс засал, эмэгтэйчүүдийн их эмч

28. Цэрэндондовын Гэрэл - Үндэсний Аудитын газрын ахлах аудитор

29. Тэгшбуянгийн Даваа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн жолооч

30. Чойнзонгийн Даваанямм - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн аж ахуйн менежер

31. Пунцагийн Даваацэнд - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн сургалтын менежер

32. Лайсуугийн Дарьсүрэн - Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургуулийн физикийн багш

33. Сүмбэрэлийн Дорж - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн технологийн багш

34. Бадраагийн Дулмаа - Хэнтий аймгийн Шүүхийн аж ахуйн нярав

35. Гэндэнгийн Дунхүү - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн эталон хадгалагч

36. Ёндонгийн Дэмбэрэлсамбуу - Төв аймгийн Лүн сумын дунд сургуулийн монгол хэлний багш

37. Цэрэнгийн Жаргалантуул - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийн физикийн багш

38. Доржсүрэнгийн Загдсүрэн - Улсын дээд шүүхийн үйлчлэгч

39. Матейн Зейнешхан - Хэнтий аймгийн Өлзийт тосгоны хүн эмнэлгийн сувилагч

40. Сэрээнэнгийн Зина - ЭМЯ-ны нөхөн сэргээх тусламжийн бодлого хариуцсан мэргэжилтэн

41. Тогтохын Ичинхорлоо - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн математикийн багш

42. Оюунбилэгийн Мөнх-Эрдэнэ - "Хүмүүсийн амьдрал" сонины ерөнхий эрхлэгч

43. Дашдоржийн Мягмар - Төрийн холбооны газрын нярав

44. Мядагийн Мягмар - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн математикийн багш

45. Минсэгийн Мягмаржав - Увс аймгийн "Шинэ ирээдүй" цогцолбор сургуулийн монгол хэлний багш

46. Ишжамцын Мяндас - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар сургуулийн орос хэлний багш

47. Төмөрийн Нанжид - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн газар зүйн багш

48. Дэндэвийн Нарантуяа - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн бага ангийн багш

49. Баатархүүгийн Наранцогт - ЭМЯ-ны Алсын түргэн тусламжийн дуудлагын жолооч

50. Даравгарын Наранцэцэг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 7 дугаар сургуулийн бага ангийн багш

51. Жамсрангийн Наранчимэг - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн монгол хэлний багш

52. Лувсандашийн Нинжжамц - Монголын сонины холбооны гүйцэтгэх захирал

53. Ломбын Одгэрэл - Үндэсний Аудитын газрын ахлах аудитор

54. Цагаандэлгэрийн Одсүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 18 дугаар сургуулийн сургалтын менежер

55. Доржсүрэнгийн Оюун - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн ахлах мэргэжилтэн

56. Пэлжээгийн Оюун - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн улсын шалгагч

57. Цэдэвийн Оюун - Эдийн засаг-Бизнесийн дээд сургуулийн дэд захирал

58. Самбуугийн Оюунгэрэл - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

59. Дамбаравжаагийн Оюунтогтох - Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дэд захирал

60. Дашдаваагийн Оюунханд - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн сургалтын менежер

61. Сүнжидмаагийн Оюунцэцэг - Сэлэнгэ аймгийн Шүүхийн шүүгч

62. Дамдинжавын Оюунчимэг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургуулийн физикийн багш

63. Цэндсүрэнгийн Оюунчимэг - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын ахлах мэргэжилтэн

64. Шагдарын Оюунчимэг - Нийслэлийн 79 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

65. Зундуйн Өлзийбаатар - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн гадаад хэлний багш

66. Цэдэвийн Саранцэцэг - Архангай аймгийн Жаргалант сумын ахлах сургуулийн технологийн багш

67. Сэмжааны Сувд - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн монгол хэлний багш

68. Балсангийн Сэржав - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

69. Самдангийн Төмөрбаатар - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн технологийн багш

70. Гомбын Тунгалаг - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

71. Цэдэнбалын Тунгалаг - Нийслэлийн Баянгол дүүргийн "Монгени" цогцолбор сургуулийн англи хэлний багш

72. Гэрэлийн Тэгшсуурь - Дорноговь аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

73. Ёндонгийн Улаан - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2 дугаар цэцэрлэгийн багш

74. Шархүүгийн Хишигсүрэн - "Сэрүүлэг" сонины дэргэдэх агентлагийн захирал

75. Дансрангийн Хумбагай - Дархан-Уул аймаг дахь Херс, агрохимийн лабораторийн захирал

76. Хайнзангийн Хумбалай - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн газар зүйн багш

77. Жимбийн Цоггэрэл - Увс аймгийн "Чандмань-Эрдэм" цогцолбор сургуулийн сургалтын менежер

78. Зундуйн Цэдэн-Иш - Нийслэлийн Налайх дүүргийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мастер багш

79. Дашнямын Цэндсүрэн - Дорнод аймгийн Матад сумын "Дов хөвөө" ББН-ийн малын их эмч

80. Түмэн-Өлзийн Цэндсүрэн - ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн дээд сургуулийн багш

81. Дугарын Цэрэндулам - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 18 дугаар сургуулийн зураг, технологийн багш

82. Сайжаагийн Цэрэнминжин - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн улсын шалгагч

83. Ваандадын Цэцгээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн захирал

84. Жамъяндоржийн Цэцгээ - Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн түүх, нийгмийн ухааны багш

85. Пунцагнамжилын Цэцэгмаа - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн менежер

86. Төмөрийн Цэцэгмаа - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Мэдээллийн сангийн эрхлэгч

87. Эрдэнийн Цэцэгмаа - Увс аймгийн "Шинэ ирээдүй" цогцолбор сургуулийн дуу хөгжмийн багш

88. Хишигсүрэнгийн Энхжаргал - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын ахлах мэргэжилтэн

89. Чилаажавын Энхжаргал - Ховд аймгийн "Прогресс" сургуулийн химийн багш

90. Бадамгаравын Энхмаа - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэргэжилтэн

91. Дамдинсүрэнгийн Энхтуяа - Нийслэлийн Баянгол дүүргийн сургалт үйлдвэрлэлийн "Сэтгэмж" цогцолбор сургуулийн сургалтын менежер

92. Бадамдоржийн Энхцэцэг - Дорнод аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дадлагын багш

93. Өлзийн Энэбиш - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн лаборант

94. Гомбожавын Эрдэнэмөнх - Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын төслийн удирдагч

95. Бадарчийн Эрдэнэтуяа - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Итгэмжлэлийн газрын мэргэжилтэн

96. Дашдоржийн Эрдэнэцэцэг - Дорнод аймгийн Нефть хангамжийн салбарын шатахуун түгээгч

97. Дэмбэрэлийн Эрдэнэцэцэг - МҮОНРТ-ийн Хүүхэд, залуучуудын ерөнхий редакцийн ерөнхий редактор

98. Ойдовын Эрдэнэчимэг - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн дуу хөгжмийн багш

99. Дэмбэрэлийн Юнгэрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн "Монгени" цогцолбор сургуулийн бага ангийн багш

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

Доржоохүүгийн Лувсанцэрэн - Дархан-Уул аймгийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 54 дүгээр ангийн багны мастер, ахлах түрүүч

**"ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР:**

Баасанжавын Амармэнд - Баянхонгор аймгийн Онцгой байдлын хэлтсийн аврагч-гал сөнөөгч, тэргүүн түрүүч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 109 | Улаанбаатар хот

**Пүрэвжавын Хаянхярваад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан цэрэг эх орны сэдэвт дуу, магтуу, марш, бүжиг, киноны хөгжим, эстрад зэрэг хөгжмийн бүх төрлөөр олон зуун шилдэг бүтээл туурвиж, дэлхийн болон үндэсний хөгжмийн зохиолчдын бүтээлүүдийг чадварлаг удирдан тоглуулж, монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмрийг нь үнэлж хөгжмийн зохиолч, удирдаач Пүрэвжавын Хаянхярваад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 110 | Улаанбаатар хот

**Чүлтэмийн Лхагважавт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухаан, боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж астраноми, астрофизик, сансрын физик, сансрын техник технологи, сансар судлал, боловсрол судлалын болон нийгмийн хөгжлийн үзэл баримтлалын чиглэлээр олон арван бүтээл туурвиж, монголд шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэн бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын зөвлөх Чүлтэмийн Лхагважавт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 111 | Улаанбаатар хот

**Дашийн Содномгомбод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Дээд боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, сургалт, эрдэм шинжилгээний олон ном, бүтээл туурвиж, оюутан залуучуудыг сурган хүмүүжүүлэх, философи, нийгмийн ухааны салбарт үндэсний мэргэжилтэй боловсон хүчин, эрдэмтдийг бэлтгэх, нийгмийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн зөвлөх, профессор Дашийн Содномгомбод Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 112 | Улаанбаатар хот

**Цэдэвийн Цэрэнд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэнд, боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол улсад эрүү, нүүрний мэс заслын албыг үүсгэн хөгжүүлэх, эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулсан хувь нэмрийг үнэлж Улсын клиникийн төв эмнэлгийн зөвлөх эмч, анагаах ухааны доктор Цэдэвийн Цэрэнд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 113 | Улаанбаатар хот |

**Баарангийн Пүрэвдашид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Хэвлэл мэдээллийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг үр дүнтэй удирдан зохион байгуулахын зэрэгцээ сэтгүүл зүйн төрлөөр олон арван бүтээл туурвиж, Монгол Улсад чөлөөт, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэн төлөвшүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монголын үндэсний олон нийтийн радиогийн захирал Баарангийн Пүрэвдашид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 114 | Улаанбаатар хот |

**Баатарын Рагчаад Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээх тухай**

Хот төлөвлөлт, барилга бүтээн байгуулалтын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, газрын харилцаа, геодези, зураг зүйн албыг үүсгэн бэхжүүлэх, барилгын салбарт үндэсний мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж ХААИС-ийн Газрын менежментийн тэнхимийн ахлах багш, дэд профессор Баатарын Рагчаад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 115 | Улаанбаатар хот |

**Махзандарын Намжилд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай**

Төрийн захиргаа, хоршооллын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд удирдлагын шинэ арга хэлбэрийг нэвтрүүлж, орон нутгийг хөгжүүлэх, ХАА-н салбарын санхүүгийн зах зээлийг өргөтгөхөд оруулсан хувь нэмрийг үнэлж Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын "Далай хөгжил" хоршооны менежер Махзандарын Намжилд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 116 | Улаанбаатар хот |

**Жаграагийн Доржсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, хими-биологи, байгаль-экологийн чиглэлээр заах арга, сурталчилгааны олон ном, материал бичиж боловсруулан сургалтанд нэвтрүүлж, сургалтын технологийг боловсронгуй болгох, сурагчдын авъяас чадварыг хөгжүүлэх талаар гаргасан амжилтыг нь үнэлж Нийслэлийн Баянзүрх дүүргийн 97 дугаар сургуулийн багш Жаграагийн Доржсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 117 | Улаанбаатар хот

**Равдангийн Дугэрсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн, багш, сурагчдын ажиллаж, суралцах таатай орчинг бүрдүүлж, боловсролын шинэчлэлийг ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, сургалтын арга барилыг боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар сургуулийн захирал Равдангийн Дугэрсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 118 | Улаанбаатар хот

**Лувсанчойдорын Алтанцэцэгт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсрол, мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хийл хөгжмийн сургалтыг олон улсын түвшинд хүргэн хөгжмийн урлагийн өндөр зэрэглэлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, Монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчилахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөгжим бүжгийн коллежийн багш Лувсанчойдорын Алтанцэцэгт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот

**Далхжавын Болормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Орон нутгийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, үндэсний сонгодог дуурь, хөгжимт драм, зохиолын болон баруун монгол ардын олон ястны дууг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, урын сангаа баяжуулан, ардын дууны урлагийг өөрийн орон төдийгүй гадаад оронд сурталчилахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Хөгжимт драмын театрын дуучин Далхжавын Болормаад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 120 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.2, 58.1.4, 58.1.5 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Өөрөө хүсэлт гаргасан тул Банзрагчийн Батбаярыг Завхан аймгийн Шүүхийн Ерөнхий шүүгчийн, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул Рашзэвэгийн Мөнх-Эрдэнийг Өмнөговь аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгчийн, Хуушааны Эрдэнэсувдыг

Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Шунуугийн Дуламжавыг Төв аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Нацагдоржийн Оюунчимэгийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Бадамсүрэнгийн Сувдааг Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 05 дугаар сарын 05-ны өдөр** | **Дугаар 121** | **Улаанбаатар хот**

### Зарим хүмүүсийг аймаг, нийслэл, сум дундын шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Хуушааны Эрдэнэсувдыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Рашзэвэгийн Мөнх-Эрдэнийг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн, Лхагвасүрэнгийн Уянгыг Хэнтий аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 02 дугаар сарын 27-ны өдөр** | **Дугаар 72** | **Улаанбаатар хот**

### Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг хавсралтын ёсоор баталж, 2008 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэж дагаж мөрдсүгэй.

2. Түр журмыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж туршилтын журмаар үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. "Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Х.НАРАНХҮҮ**

**Засгийн газрын 2008 оны 72 дугаар тогтоолын хавсралт**

## ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЖ БАЙГАА ИРГЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү түр журмын зорилго нь хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж албан ёсны хөдөлмөр эрхлэлт болон бичил уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэх бэлтгэлийг хангах, нөхөрлөлд олгох газрыг тогтоох, гэрээгээр ашиглуулах, бичил уурхайн техник, технологи нэвтрүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдүүлэх харилцааг зохицуулахад оршино.

2. Энэхүү түр журмыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр иргэд хувиараа ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах Монгол Улсын хууль батлагдах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

3. Энэхүү түр журмаар ус, цацраг идэвхит элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг иргэд хувиараа олборлож байгаа үйл ажиллагааг зохицуулна.

4. Энэхүү түр журамд дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1. "Хувиараа ашигт малтмал олборлох" гэж энэхүү түр журамд заасны дагуу сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан нөхөрлөл ашигт малтмалыг гар багаж, эсхүл бага оврын техник, тоног төхөөрөмж ашиглан хоногт дор дурдсан хэмжээний ашигт малтмал олборлох болон уулын ажил гүйцэтгэхийг хэлнэ:

4.1.1. 25 тн хүртэл хүдэр, эсхүл нүүрс, жонш олборлох;

4.1.2. 200 $м^3$ хүртэл хэмжээний уулын ажил гүйцэтгэх.

4.2. "Нөхөрлөл" гэж Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу хамтран ажиллах гэрээний үндсэн дээр бүртгэгдээгүй нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж энэхүү түр журамд зааснаар үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг хүмүүсийг,

4.3. "Бага оврын техник, тоног төхөөрөмж" гэж 500 $см^3$ хүртэл багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг,

4.4. "Нэгж талбай" гэж нөхөрлөлийн нэг гишүүнд ногдох хойноос урагш, баруунаас зүүн чиглэлтэй шулуун шугамуудаар хүрээлэгдсэн хэсэг талбайг.

**Хоёр. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулахад нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг**

5. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг:

5.1. Нутаг дэвсгэр дээр нь иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгаа сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах талаар авч хэлэлцэн дараахь шийдвэрийг гаргана:

5.1.1. тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэр дээр иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжүүлэх тухай;

5.1.2. иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нөхөрлөлийн зохион байгуулалтаар хэрэгжүүлэхэд зориулж тухайн сум, дүүргийн нутагт ашиглуулах боломжтой газрын талаар хэлэлцэн тогтоож, тухайн газрын ашигт малтмалын нөөцийн талаар мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт гаргуулах талаархи саналаа геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тухай;

5.1.3. иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэхүү түр журмын дагуу зохион байгуулах арга хэмжээний тухай.

5.2. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт иргэд хувиараа ашигт малтмал олборлоход зориулан тогтоосон газрын тоо нь 2-оос илүүгүй байж болно.

5.3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан үнэлгээ, дүгнэлтээр энэхүү түр журмын 5.1.2-оор тогтоосон газар нь иргэд хувиараа ашигт малтмал олборлоход зориулалтаар ашиглахад тохирохгүй болох нь тогтоогдсон тохиолдолд өөр газрыг тогтоох, эсхүл тухайн сум, дүүргийн нутагт иргэд хувиараа ашигт малтмал олборлох бололцоогүй болсон тухай шийдвэрийг гаргана.

5.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг иргэдэд зарлан мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

6. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг:

6.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн дагуу иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас иргэд хувиараа ашигт малтмал олборлоход зориулан тогтоосон газарт ашигт малтмал олборлож болох талбайн солбицол болон энэхүү түр журмын 5.1.2-т заасан шийдвэрийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;

6.3. Тогтоосон газрын нөөцийн талаар мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт гарсан тохиолдолд иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэхүү түр журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.4. Сум, дүүргийн хэмжээнд ашигт малтмал олборлох зориулалтаар олгосон талбайн зураг зүйн бүртгэлийг хөтөлж, тэнд ажиллаж байгаа нөхөрлөлийн гишүүд, тэдгээрийн өрхийн гишүүдийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөх;

6.5. Нөхөрлөлийн гишүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн болон нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах арга хэмжээ авах;

6.6. Нөхөрлөлийн гишүүдийг татвар, даатгалд хамруулах арга хэмжээ авах;

6.7. Хууль тогтоомжийн биелэлт, нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах ажлыг зохион байгуулах;

6.8. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар нөхөрлөлөөс авсан арга хэмжээний тайланг газар дээр нь шалгаж стандартын шаардлагад нийцүүлэн хүлээн авсан тухай мэдээллийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад улирапд 1 удаа хүргүүлэх;

6.9. Нөхөрлөлийн олборлолт явуулсан талбайд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг холбогдох журмын дагуу тооцож зохих хөрөнгийг мөнгөн хөрөнгийн хуримтлалын санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.

7. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг:

7.1. Энэхүү түр журмын 6.2-т заасан хүсэлтийн дагуу иргэд нөхөрлөлийн хэлбэрээр хувиараа ашигт малтмал олборлоход зориулан тогтоосон газарт байгаа ашигт малтмалын нөөцийн талаар геологийн судалгааны мэдээлэлд тулгуурлан ажлын 15 хоногт үнэлгээ, дүгнэлт гаргаж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

7.2. Тогтоосон газрын ашигт малтмалын нөөцийн талаархи геологийн судалгааны мэдээлэл хангалтгүй гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн 2-оос доошгүй геологичийн бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгийг томилон явуулж газар дээр нь болопцоотой тандалт, судалгаа хийж ажлын 30 хоногт багтаан үнэлгээ, дүгнэлт гаргаж өгөх;

7.3. Нэгж талбайн хэмжээг ашигт малтмалын төрөл, нөөцийн үнэлгээ, уул, геологийн нөхцөлөөс нь хамааруулан тогтоох аргачлал боловсруулж мөрдүүлэх;

7.4. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар боловсруулж холбогдох яам, агентлагаар батлуулан мөрдүүлэх;

7.5. Хувиараа ашигт малтмал олборлох тухай нөхөрлөл, сум, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах гэрээний болон нөхөрлөлийн гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээний загвар, нөхөрлөлийн үлгэрчилсэн дүрэм, ашигт малтмал олборлох гэрээ байгуулах талаар сум, дүүргийн Засаг даргад нөхөрлөлөөс гаргах өргөдлийн маягтын үлгэрчилсэн загварыг баталж сум, дүүрэгт хүргүүлэх;

7.6. Нөхөрлөлийн гишүүдэд геологи, уул уурхайн үйлдвэрлэлд ажиллах мэргэжлийн чиг баримжаа олгох, аюулгүй ажиллагааны арга барил эзэмшүүлэх сургалтыг сум, дүүргийн Засаг даргатай хамтран зохион байгуулах;

7.7. Хувиараа ашигт малтмалыг нөхөрлөлийн хэлбэрээр олборлох үйл ажиллагаатай холбогдон нөхөрлөлийн гишүүдийг сургаж, дадлагажуулахад эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн байгууллага, үйлдвэр, сургууль, инженер техникийн ажилтнуудыг оролцуулах;

7.8. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдэрдсэн унаган төрхөө алдсан газарт байгаль, экологийн нөхөн сэргээлт хийх шаардлага, техникийн нөхцөлийг байгаль орчны мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулан баталж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

8. Энэхүү түр журмын биелэлтэд Улсын мэргэжлийн хяналтын газар, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч, төрийн бус байгууллага, иргэд хяналт тавина.

**Гурав. Иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтаар ашигт малтмал олборлох газрыг тогтоох**

9. Иргэд нөхөрлөлийн зохион байгуулалттайгаар ашигт малтмал олборлох газрыг дараахь үндсэн 3 ангиллын дагуу тогтооно:

9.1. ашигт малтмалын нөөц болон чанарын хувьд том үйлдвэр, уурхайгаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, илэрцийн талбай;

9.2. нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон уурхайн эдэлбэр газар болон уурхайн ашиглалтын технологийн хаягдал болон үүсмэл ордын талбай;

9.3. ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас тухайн зөвшөөрөл эзэмшигч, сум, дүүргийн Засаг дарга, нөхөрлөлийн хооронд байгуулсан гурвалсан гэрээгээр нөхөрлөлд ашиглуулах боломжтой талбай.

10. Хувиараа ашигт малтмал олборлох зориулалтаар дараахь газрыг сонгохыг хориглоно:

10.1. хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хамгаалалтад байгаа газар нутаг, Ашигт малтмалын тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан нөөцөд болон тусгай хэрэгцээнд авсан газарт;

10.2. ашигт малтмалын хайгуулын талбай болон ашиглагчтай нь гэрээ байгуулаагүй тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай;

10.3. нутгийн иргэдийн тахиж шүтдэг газар нутаг, уул овоо, оршуулгын газар болон малын отрын бэлчээр нутаг;

10.4. нөөц тогтоогдсон ордын үйлдвэрлэлийн аргаар олборлох боломжтой талбай;

10.5. хот, тосгон бусад суурин газрын нийтийн эдэлбэрийн газар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар;

10.6. ойн болон усны сан бүхий газар;

10.7. зам болон шугам сүлжээний газар;

10.8. энэхүү түр журмын 9.1, 9.2-т зааснаас бусад ашигт малтмалын үндсэн орд.

**Дөрөв. Иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтад орох, нөхөрлөлд олгох талбай**

11. Иргэд хувиараа ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр мөн хуулийн 481.1 дүгээр зүйлд заасан бүртгэгдээгүй нөхөрлөл болон зохион байгуулагдсан байна.

12. Нөхөрлөлийн үйл ажиллагаа нь Иргэний хуулийн 477-482 дугаар зүйл болон нөхөрлөлийн дүрмийн дагуу зохицуулагдана.

13. Энэ түр журмын 11–д заасны дагуу зохион байгуулагдсан нөхөрлөл нь оноосон нэртэй байна. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нөхөрлөл нь өөр нөхөрлөлтэй давхардсан нэртэй байж болохгүй.

14. Нөхөрлөлийн гишүүдийн тоо нь 2-100 хүртэл байж болно.

15. Нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

16. Энэхүү түр журмын 11-15-д заасан нөхцөлийг биелүүлсэн нөхөрлөлтэй сум, дүүргийн Засаг дарга ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулж талбай олгоно.

17. Нөхөрлөлд гэрээгээр олгох талбай нь нөхөрлөлийн гишүүн бүрт ногдох нэгж талбайн нийлбэрээс бүрдэх бөгөөд дээд хэмжээ нь 25 гектараас илүүгүй байна.

18. Нөхөрлөлд талбайг 1 хүртэл жилийн хугацаатай олгож, хугацааг нэг нэг жилээр сунгаж болно.

**Тав. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдөл гаргах**

19. Нөхөрлөл ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргад энэхүү түр журмын 2.5-д заасан маягтын дагуу бичгээр гаргана.

20. Өргөдөлд дараах зүйлийг заавал тусгана:

20.1. нөхөрлөлийн нэр, нөхөрлөлийн ахлагч буюу эрх бүхий төлөөлөгч болон гишүүдийн нэр, хаяг;

20.2. талбайн байршил, хэмжээ;

20.3. олборлох ашигт малтмалын төрөл.

21. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

21.1.нөхөрлөлийн гишүүд болон тэдгээрийн хамт тухайн орон нутагт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийн иргэний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар;

21.2. нөхөрлөлийн гишүүдийн хооронд бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээ;

21.3. олборлолт явуулах талбайн булангийн цэгийн солбицол, байршлын зураг;

21.4. нөхөрлөлийн гишүүний албан татвар төлөгчийн гэрчилгээ, дэвтрийн хуулбар.

22. Нөхөрлөлийн гишүүдэд дараах шаардлага тавигдана:

22.1. Монгол Улсын иргэн байх;

22.2. 18 нас хүрсэн байх;

22.3. тухайн орон нутагт байнга оршин суугчаар бүртгүүлсэн байх.

23. Энэхүү түр журмын 20-22-т заасан шаардлага хангаагүй өргөдлийг хүлээн авахгүй.

24. Нөхөрлөл олборлолт явуулсан талбайг буцааж хүлээлгэн өгсний дараа зөвшөөрөгдсөн өөр талбайд ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлийг сум, дүүргийн Засаг даргад гаргаж болно.

25. Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан дараах зүйлийг тодруулна:

25.1. энэхүү түр журмын 20-д заасан шаардлагыг хангасан эсэх;

25.2. энэхүү түр журмын 21-д заасан баримт бичгийг бүрдүүлсэн эсэх;

25.3. өргөдөлд заасан талбай нь энэхүү түр журмын 9-д заасан газарт хамрагдах эсэх;

25.4. тухайн нөхөрлөл өмнө нь олборлолт явуулж байсан бол байгаль орчны техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн эсэх.

26. Өргөдөл, хавсаргасан баримт бичиг энэхүү түр журмын 25-д заасныг хангасан тохиолдолд өргөдлийн бүртгэгдсэн дараалдын дагуу гэрээ байгуулна.

**Зургаа. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах**

27. Энэхүү түр журмын 9.1, 9.2-т заасан талбайд ашигт малтмал олборлох нөхөрлөл тухайн сум, дүүргийн Засаг даргатай бичгээр гэрээ байгуулна.

28. Гэрээнд дараах зүйлийг тусгана:

28.1. талуудын эрх, үүрэг, хариуцлага;

28.2. талбайн байршил, хэмжээ;

28.3. гэрээний хугацаа, түүнийг сунгах нөхцөл;

28.4. энэхүү түр журмын 9.1, 9.2-т заасан газрыг ашиглуулах нөхцөл;

28.5. байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр хийх ажил;

28.6. олборлох ашигт малтмалын төрөл;

28.7. ашиглалтын технологийн заавар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн норм, стандартыг мөрдөх журам, нөхцөл;

28.8. нөхөрлөлийн гишүүдийг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамруулах нөхцөл;

28.9. химийн хорт болон тэсрэх бодис зөвшөөрөлгүй хэрэглэхгүй байх тухай үүрэг;

28.10. гэрээг цуцлах болон дуусгавар болох үндэслэл;

28.11. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг сахин биелүүлэх, түүнийг зөрчсөнөөс үүсэх гарах хариуцлага;

28.12. бусад зүйл.

**Долоо. Талбайг буцааж хүлээлгэн өгөх**

29. Нөхөрлөл дараах нөхцөлд талбайг буцааж хүлээлгэн өгнө:

29.1. талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглаж дууссан;

29.2. гэрээгээр авсан талбайн нөөц нь үр ашиггүй болох нь тогтоогдсон;

29.3. уул, геологийн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон;

29.4. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон;

29.5. нөхөрлөл талбайг хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан;

29.6. нөхөрлөлтэй байгуулсан гэрээг цуцалсан;

29.7. тухайн талбайг нөөцөд болон тусгай хэрэгцээнд авсан.

30. Нөхөрлөл талбайг буцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлага, техникийн нөхцөлийг баримтлан хийнэ.

**Найм. Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хориглох зүйл**

31. Нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

31.1. арван найман нас хүрээгүй иргэн, жирэмсэн эмэгтэй, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан хүнийг ажиллуулах;

31.2. технологийн заавар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм зөрчих;

31.3. зориулалтын бус газар, гол, горхи, булаг, шанд болон нууранд ашигт малтмал агуулсан шороо, хүдрийг угааж баяжуулах;

31.4. албан татвар төлөгчийн гэрчилгээ аваагүй;

31.5. нөхөрлөлийн гишүүн бус этгээд олборлох үйл ажиллагаанд оролцох;

31.6. зөвшөөрөлгүйгээр химийн хорт болон аюултай бодис ашиглах;

31.7. зөвшөөрөлгүйгээр тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

31.8. нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах.

**Ес. Онцгой нөхцөл**

32. Нөхөрлөлийн алтны үндсэн ордоос олборлосон хүдрийг баяжуулах үйл ажиллагааг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжийн баяжуулах цехэд тогтоосон цэгт явуулна.

33. Баяжуулах цех байгуулах аж ахуйн нэгжийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгон шалгаруулна.

34. Баяжуулах цех байгуулахаар шалгарсан аж ахуйн нэгж нь тухайн газрын байгаль орчны ерөнхий үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын байгаль орчны албаар хийлгэнэ.

35. Нөхөрлөлийн олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг Монгол банкнаас тогтоосон журмын дагуу тухайн орон нутагт байнга оршин суудаг, итгэмжлэгдсэн, эрх бүхий дилер худалдан авна.

**Арав. Бусад зүйл**

36. Нөхөрлөл нь уул уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг зөрчсөний улмаас гишүүний эрүүл мэнд, амь нас хохирсон тохиолдолд хариуцлагыг тухайн нөхөрлөлийн эрх бүхий төлөөлөгч, гишүүд хүлээнэ.

37. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сум, дүүргийн Засаг дарга, эрх бүхий улсын байцаагч Захиргааны хариуцлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
12 цаг 50 минут

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд П.Очирбат, Н.Жанцан, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Лхагважав, мөн хорооны оршин суугч, иргэн Б.Баярсайхан нар ирсэн ба Улсын Их Хурлын даргын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 50 тоот захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-үүл, Су.Батболд нар цэцийн хуралдаанд оролцоогүй болно.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Бат-Үүл Үндсэн хуулийн цэцэд хандаж 2008 оны 5 дугаар сарын 2-нд гаргасан хүсэлтдээ Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг хойшлуулах тухай, 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр гаргасан хүсэлтдээ Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд биечлэн оролцох талаараа тус тус хүсэлт гаргасныг цэцийн их суудлын хуралдааны бүрэлдэхүүн хэлэлцээд хуралдааныг хойшлуулах хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй байна, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуралдаанд оролцох боломжтой байсан байна гэдэг үндэслэлээр хүсэлтийг хүлээн авалгүй орхиж, Их суудлын хуралдааныг үргэлжлүүлэхээр ам магадлал гаргав.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцсэн ба Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Улсын Их Хурлын 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

***Нэг. Иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нар 2008 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөлдөө:***

"Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвсэлийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5-т "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр суурийнаас хандаж үг хэлэх, санал хураалтанд оролцох" гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь зүйлийг зөрчсөн байна. Үүнд:

1. Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"

2. Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"

3. Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхолыг эрхэмлэн баримтлана".

4. Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн байна.

Иймд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн "Монгол Улсын Их хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтуудыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

***Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, Д.Дондог нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

"... Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн тухай Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нарын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлтэй танилцаад дараахь тайлбарыг гаргаж байна.

Аливаа улс оронд "нийгмийн ашиг сонирхол болон өөрсдийн /хувийн/ үзэл бодлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэж" нам байгуулах үйл ажиллагаа нь тухайн нийгмийн улс төрийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр байдаг. Тийм ч учраас 2005 онд батлагдсан Улс төрийн намын тухай Монгол Улсын хуулийн 4.1-д "Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн" гэж тодорхойлсон. Энэ нь аливаа намын гол зорилго нь засгийн эрхийг барихын төлөө үйл ажиллагаа байдаг.

Ялангуяа улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөр нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаалсан, нийгмийн амьдралын төлөө юу хийж чадах тэр бүхнийгээ төлөвлөн дэвшүүлэн тавьдаг. Тухайн намын энэхүү мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө ард түмнийгээ төлөөлөн парламентын гишүүн ажиллах шаардлагатай болдог. Энэ агуулгаар аваад үзэхэд сонгогч нэр дэвшигчийг дэмжиж санал өгч байгаа ч тэр нэр дэвшигчийн харьяалах намын мөрийн хөтөлбөрийг дэмжиж байгаа хэрэг гэж үздэг.

Тухайн нам нь Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байдаг бөгөөд хувь хүн хувийн үзэл бодол, санаагаараа тэдгээрийг дэмжиж, түүнтэй санал нэгдсэний үндсэн дээр гишүүн нь болж үйл ажиллагаанд нь оролцдог. Энэ байдал ч парламентад суудалтай намуудын үйл ажиллагаанд илэрхийлэгдэж байдаг.

УИХ дахь намын бүлэг бүрээр хэлэлцэж байгаа асуудал нь сайн шүүгдэж, нэгдмэл санаанд хүрсэн бол чуулганы хуралдаан дээр үр ашиггүй маргаан, санал зөрөлдөх явдал бага гарна гэж үздэг. Энэ жишиг парламентат улс орнуудад нийтлэгээр дагаж мөрдөгдөж байна. Улс төрийн намын бүлэг нь парламентын ганц гишүүнээс илүүгээр Засгийн газар, нийгэм хоёрыг холбох гол үүргээ гүйцэтгэж чаддаг болох нь амьдралаар нотлогдсон гэж үздэг. Нөгөө талаар намын сахилга бат бол парламент дахь улс төрийн намын бүлгийн чадвар, түүний гишүүдийнх нь удирдлагынхаа бодлогыг хэр дэмжиж байгаад оршдог.

Олон улсын практикаас харахад ардчилсан либерал үзэл ихэвчлэн намын лидерууд парламентын гишүүн болж байдаг буюу "удирдлагыг дамжуулдаг" тогтолцоо байдаг. Намын сахилга бат нь Вестминстер тогтолцооны шиг болон Англи, Канад, Австрали, Энэтхэг шиг их хатуу байх хандлагатай байдаг. Энэ нь Засгийн газрын эсрэг парламентад санал хураалгадаггүй байдал нь Засгийн газрын бодлогыг "унагах, сүйрэлд" оруулахгүй байхаар тохиролцохоос гадна намын байр суурийг гишүүд дэмжиж ажилладагтай холбоотой юм. Энэ нөхцөл байдалд өөрийн намын хүсэл, бодлогын эсрэг ажиллах гишүүд ховор байдаг. Тийм учраас намын байр суурийг харгалзан парламентын санал хураалтад оролцдог байна.

Онолын хувьд парламентын гишүүн бол ард түмний элч, тэднийг төлөөлж байдаг. Гэхдээ практикт парламентын гишүүн нь намаас нэр нь дэвшигдэж, ард түмэн түүнийг сонгох, эс сонгохоо шийддэг. Тухайн нэр дэвшигч ард түмнээс сонгогдож гарч ирдэг боловч өөрийн харьяалах намтайгаа гэрээ байгуулж нэг талаас улс төрийн бодлогыг тодорхойлоход намын байр суурийг, нөгөө талаас ард түмний нийтлэг эрх ашгийг тус тус илэрхийлж оролцох шаардлагатай болдог. Энэ агуулгаар авч үзвэл ямарч нөхцөлд парламентын гишүүн хоёрдмол байр сууринд ирдэг. Иймээс ихэнх улс оронд парламентын гишүүний энэхүү хоёрдмол байр суурийг зохицуулах үүднээс тодорхой асуудлуудыг ялангуяа улс төрийн бодлогын үүднээс хандах асуудалд парламент дахь намын бүлгийн баримталж байгаа зарчим, бодлогыг дагаж мөрдөхөөр зохицуулдаг нь үүнтэй холбоотой юм.

Гэхдээ зөвхөн улс төрийн шалтгаанаар ийнхүү нэгдэж ажилладаг бөгөөд иймч учраас бүх асуудлаар бус зөвхөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, улсын төсвийг хэлэлцэхэд л УИХ дахь нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгож гишүүн байр сууриа илэрхийлж байхаар тусгасан юм. Ялангуяа парламентад олонхи суудал авсан улс төрийн намын үйл ажиллагааны болон

сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болдог бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг тул намын сахилга батыг илүү харгалзах шаардлага гарч байдаг. /парламентад суудалтай бусад намд ч энэ байдал хамаарч байдаг/

Энэ бүхнээс үзэхэд дээрх заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д дээрх тусгайлан заасан асуудлаас бусад асуудлыг хэлэлцэхэд УИХ-ын гишүүн өөрийн үзэл бодол, байр суурьнаас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцохоор заасан бөгөөд энэ заалтыг мөн адил Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай өргөдөл гаргагчид үзсэн байна. Хуулийн 8.1.4-т тусгайлан заасныг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн атлаа өөрийн үзэл бодлоор хандах энэ заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хоорондоо зөрчилдөж байна. УИХ-ын гишүүний нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмаар, эсхүл өөрийн үзэл бодлоор хандахын аль алиныг нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь ойлгомжгүй байна.

Тэгвэл гишүүн асуудалд хэрхэн хандах ёстой вэ, өөр гуравдахь хандлагаар хандах хэрэг гарч байгаа биш үү. Тэгээд ч өргөдөл гаргагчид Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд нь ямар үндэслэлээр Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа талаар огт дурьдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, иргэн Б.Лхагважав, Б.Баярсайхан нар Цэцэд өргөдөл гаргахдаа түүнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог тусгаагүй байна.

Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж өргөдөл, мэдээлэл нь энэ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тогтоол гаргахаар заасан.

Дээр дурьдсан үндэслэлээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй гэж үзэж байна" гэжээ.

***Гурав. Үндсэн хуулийн цэц энэхүү маргааныг 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж 04 дүгээр дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтэд:***

"1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх, 8.1.5 дахь заалтын "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5 дахь заалтын "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад ..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох" мөн 8.1.5 дахь заалтын энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7/-д заасан "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэснийг зөрчөөгүй байна" гэжээ.

***Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцээд хүлээн зөвшөөрөх***